

Толь бичгээ эргэж харах цаг

Ц.Базаррагчаа* (МУИС)

Ээ Монголоо алд...! Бага байхад минь явган суухад:

-Монголоо алдсан! зөв суу! хэмээн зандран засдаг байлаа. Өнөө өгөл насны өндрөөс эргэцүүлбэл наяд жилийн тэртээ гэрт исгэрэх, орондоо дуулах, босоо шээх, шувууны өндгөнд сүүдрээ тусгах тэр бүхэн цээртэй. Цээртэй үйл үйлдэх болгон Монголоо алдаж байгаа явдал байлаа. Тэгвэл өнөө босоо шээх монгол ёс явдал болон хэвшээд, өндгөнд сүүдрээ тусгах бол Монголоо алдаж буй хэрэг огтхон ч биш бүүр алж хяддаг болов.

Өнөөгийн бидний Монгол, Манжийн 220 жил дээр Оросын 70 гаруй жилийн хүчирхийллийг нэмээд 300 гаад жилд Монголоо алдан алдсаар юутай үлдсэн байнам.

Энэ цагийн содон найрагч Зундуйн Доржийн сонгодог тодорхойлолт <<хил, хэл, мал гурав>> -аас үлдэх юм юу байна вэ?

Монгол гэрийн дээврийн чинээ нутагтай байснаасаа Хятад, Орос хоёр их хөршдөө зулгаалгасаар үлдсэн <<дэлгэсэн тэрлэг>> -ийн чинээ нутаг дэвсгэрээ хилчид маань нүд цавчилгүй харж хамгаалсаар байгаа гэнэм. Мал сүрэг гэвэл байнаа байна. Байхаар барахгүй, өсч үржсээр 50 саяд хүрчээ. Тэр олон малыг маань их урт гээгтэй, сав л хийвэл Оросоор хараал тавидаг, Хятад төмөр унаатай шинэтгэл цагийн малчид адгуулж явна. Мориор биш моторт унаагаар малаа хариулдаг малчидтай болсоон. Хоттой хонь малдаа машин тэрэг ойртуулдаггүй байсан Булган аймгийн алдарт хоньчин Очир баатар, тэр хүний залгамж болсон Намхайнямбуу баатарын үеийн малчид цөм бурханыхаа оронд оджээ.

Улсын хил, тэр хилийн доторхи мал хоёрынх нь тухайд бол иймэрхүү шигээ. Харин одоо үлдсэн нэг нь болох хэл болон бичгийнх нь тухай тодруулая.

<<хил, хэл, мал гуравтайгаа бол хэн баян бэ? Монгол баян>> гээд байгаа! Энэ яалтгүй үнэн! үнэн!

Би хятад хэл, бичгийг гадарлахын төдийл хүн. Хятад хэл, дөрөв таван ч хөгтэй, хөгжимлөг хэл. Хятад бичиг хөндлөн ч бичиж болдог, босоо ч бичиж болдог элдэвтэй. Манай монгол бичиг шиг хүний ярисныг ба бэ-гүй хурдан таталган бичиж болдог ч аялгуу яруу, эх хэл юунд минь, нутаг нутгийнхаа аялгуунд таацсан Монгол бичигт минь яахин хүрэхсэн билээ.

*МУИС-ийн ГХСС-ийн зөвлөх профессор, доктор

Манжийн ноёрхлын 220 жилийн явдлыг үл өгүүлэн өгүүлэхэд, сүүлхэний дал наян жилийн турш Монгол хэл, Монгол бичиг минь ад шоо үзэгдэн, элдэв эснээр муучлагдсаар ирсэн түүх бол саяхных.

“...хуучин бичиг бол олон зуун жил болсон үсэг... Өнөөдрийн байдлаас хоцорсон нь үнээн. Ирээдүйд нэг хэл, нэг бичигтэй болох онол бий шүү дээ” (Ю.Цэдэнбал 1962.5.8) Энэ үг бол Ю.Цэдэнбалын үг биш, И.В.Сталин бусад улс орны хэлийг тухайлбал Монгол хэл, Монгол бичгийг Оросчлох бодлогоо Цэдэнбалын амаар хэлүүлсэн хэрэгээ. Сталины Монгол хэл, бичгийг устгах бодлого 1940-оод онд Монгол бичгийг кирилл бичгээр солисон үеэс улам эрч хүчээ авсаар сургуулиудад үзэх Орос хэлний хичээл, шалгалтын цаг, эх хэлнийхээс минь их болж, дунд, дээд, их сургууль төгсөгчид улсын шалгалтаа эх хэлээрэн биш Орос хэлээр шалгуулдаг болоод хожим нь их дээд сургуулийн бүх хичээлийг Орос хэлээр заах болж, боловсон хүчнийг шилж сонгох цорын ганц шалгуур нь Орос хэлний чадвар болж байлаа.

Чухам энэ л чанадын нарийн учир, хэтийн зорилгоор Монгол хэлнээ бэлхэнээ байж л байгаа өдий төдий Монгол үгийн оронд Орос болон Орос хэлээр дамжин орж ирсэн үгсийг тэр чигээр нь авсаар ирсэн нь тэр хахир хатуу үед буюу социализмын үед хэвлэгдсэн “Монгол-Орос толь бичиг” “Монгол хэлний товч тайлбар толь” “Орос-Монгол толь бичиг”-д толгой үсгээр орсон нь өнөөдөр гадаад дотоодод хэвлэгдэж байгаа хэл хэлний толь бичгүүдэд мөнөөхөн тэр чигээрээ орсоор байна. Эн тэргүүнээ эдгээр толь бичгүүдийн К, П үсгээр толгойлсон үгсийг онцолмоор байна.

Би энд 21-р зууны гучаад онд гарсан Я.Шмидтийн “Монгол-Герман-Орос” толь, О. Ковалевскийн “Монгол-Орос-Франц толь”, К.Ф.Голстунскийн “Монгол-Орос толь”, А.Мостартын “Ордос-Франц толь”-иудаас биш бүүр сүүлийн үеийн толиудаас жишээ авч байна. 1966 онд хэвлэгдсэн <<Монгол хэлний товч тайлбар толь>>-ны К-толгой үсгийн цувааны нийт 155 үг бүгд гадаад үг байна. Монгол хэлний тухайд толь бичигт “К” үсгээр толгойлчих үггүй гэхээр онцлогтой ч гарцаагүй гадаад үгээр нь авсан кино, километр, киловатт зэрэг хэдийнээ манай үгсийн санд идээшсэн 10 хүрэхгүй үгээс бусад 140-өөд үг нь утга дүйцэх Монгол үг бүхий, улсын нэр томъёоны зөвлөл гэж байх үеэс баталгаажсан үгс байна. Жишээ нь: календарь-цаг тооны бичиг, кассет-хуурцаг, категори-ай, аймаг, бүлэг; колбаса-хиам, комисс-зөвлөл, хороо; кран-цорго, өргүүр гэх мэт үгс байна. 1999 онд Бээжинд хэвлэсэн <<Шинэ Монгол Хятад толь>>-ны К толгой үсэг болон Д.Болдбаатарын 2003 онд хэвлүүлсэн <<Монгол Хятад толь бичиг>>-ийн К толгой үсэг 180-аад болж олширсон нь компьютер, конгресс, код, ковбой, коктейл мэт сүүлхэн гарч ирсэн үгс байна. Сүүлийн жилд Англи, Япон, Солонгос зэрэг хэл суралцагсад ч олон болж, хэл хэлний толь бичиг ч олон гарчээ. Энэ нь гадаад хэл эхлэн суралцагсадын хэрэглээг хангасан яалтгүй буянт үйл мөн. Гэвч тэр толь бичгүүд нь 50 гаруй жилийн өмнө, оросчлох бодлогын хаяхаан дор бүтээсэн <<Монгол-Орос толь>>, <<Монгол хэлний товч тайлбар толь>>-ийг эх загвар болгосон учир зохиомж, бүтцийн хувьд яг адилхан байна. Усны эх нь булингартай бол урсгал нь булингартай гэдгийн жишээ энэ мөн. Усны эх нь булингаргүйн жишээг бас эш татаж болох байна. Хятад үгийн адармаатай утгыг зөв тайлах гэж үгийн эрэлд хатахдаа 1955 онд Москва-д хэвлэсэн <<Китайско-Русский словарь>>-ыг сөхөх болдог. Профессор И.М.Ошаниний редакцын дор боловсруулсан тэр толь бичгийг зохиож байх тэр цаг Оросын Нанхиад судлалын оргил үе буюу алтан үе таарчээ.

И.М.Ошаниний толийн үг оноолт буюу хоёр хэлний үгийн утгын жин яв цав тохирдог нь үнэнхүү бишрэм билээ. 1955 оноос хойш Москвад ч, Бээжин, Шанхайд ч Орос-Хятад, Хятад-Орос том том толь бичиг олон гарчээ. Тэр бүхэн И.М.Ошаниний

толийг эх дэвсгэр болгодгийн учир хоёр хэлний үгийн утгын жин тааруулан оноон толилсон нь үнэнхүү үлгэр жишээ болдог билээ.

Өмнө нэрлэсэн толь бичгүүд дэхи “К ” толгой үсгээр эхэлсэн гадаад үгсийн зууны ерэн зургааг Хятадын толь бичгүүдэд утга таарах Хятад үгээр оноосон байх юм. Чингэхээр Монгол хэлнээ орчуулах үггүй тэдгээр гадаад үгсийг Хятад хэлнээ орчуулаад байгаа нь Монгол хэлний үгийн сан нэн ядуугийнх болж таарна бизээ. Жишээ нь: манай орчуулах боломжгүй гэж үзээд гадаад үгээр нь толилдог конвенцийг гэрээ, тусгай гэрээ, конвертийг захидлын дугтуй, конспектийг хураангуй, товчлол, костюмыг барууны хувцас гэхчилэнгээр орчуулан толилсон байдаг байна.

Хятад хэлнээ харь үг аль болох бага авахыг ихэд эрхэмлэдэг боловч кока кола, гольф, трактор, комбайн, кара-окей мэт гадаад үгсийг авсан байдаг. Харь үгийг авахдаа уг гадаад үгийн дуудлагыг ханз үсгээрээ галиглахдаа ханзныхаа утга илтгэдэг давууг хэрэглэдэг онцлогтой. Кока кола-гэдгийг ke kou ke le (可口可樂) гэсэн ойролцоо дуудлагатай ханз үсгүүдээр галигласан нь *уугууштай цэнгүүн* гэсэн утга, трактор гэдгийг tou la ji(拖拉机) гэсэн дуудлага ойролцоо, *түрдэг татдаг тэрэг* гэсэн утгатай ханзаар галиглан авсан байдаг юм.

Орос, Хятад хоёр хэл уугуул Монгол хэлний минь үгийг эзлэн түрэмгийлээд бүр толь бичгийн толгой үсгийн орон зай эзэлсний ганц ганц жишээ татая. Өмнө миний дурдсан толь бичгүүдэд Л толгойт үсгийн цуваанд *лоом* гэдэг үгийн ард *царил* гэдэг үг тависан байх бөгөөд Ц толгойт үсгийг үзвэл *царил* гэдэг үгийн ард *лоом* гэсэн байх бөгөөд мөнөөх тольнуудын Ш толгойт үсгийн цуваанд *шанз* гэдгийн ард гурван чавхдаст хөгжмийн зэмсэг гээд *шудрага* ч гэдэг гэжээ. Цааш Ш толгой үсгийг гүйлгэн үзвэл *шудрага* гэсэн үгний ард *шанз* гэсэн байх юм. *Лоом* нь Орос, *Шанз* нь Хятад үг л дээ. Хөөрхий Монгол хэл минь хоёр их гүрний хэлнээ хөрөөдүүлсээр ирсэний жишээ энэ ээ.

Толь зүйн тухайд шинэчлэх юм нэг биш байгаагийн өөр нэг жишээ гэвэл ойромгхон хэвлэгдээд байгаа аль ч хэлний толь бичгүүдэд үйл үгийг үндсээр нь оноодог жишгийг огт хэрэгсэхгүй байгааг яалаа ч зөвтгөшгүй. Үйл үгийн үндсээр толилсны жишээнд Домийн Төмөртоого Японы Монголч их эрдэмтэн Озава Шигэо, Хасуми нарын зохиосон “Орчин цагийн Монгол-Англи-Япон толь” 1979 (Токио), эрдэмтэн Ц.Сумьяагийн “Орчин цагийн Англи-Монгол толь”(2002) мэтийг дурдаж байна. Ээж шиг минь сайхан Монгол хэл минь, ижил нь үгүй сайхан Монгол бичиг минь энэ л цагийн элдэв шидийн хэлээр бичсэн хаяг даяг, зар сурталчилгаагаар эрээн цоохортсон Улаанбаатарын гудамж шиг болчихлоо. Манай нийслэлийн гудамжинд “хиймэл бэлгэ эрхтэний дэлгүүр” гэсэн салаа утга илтгэдэг Англи хаяг байна гэнээ.

Даяаршил хэмээх рах¹ бидний ээх наран болсон эх хэл, эрдэнийн бичгийг минь ийнхүү залигаж байхад ядаж түмпэн сав, тогоо шанагаа нүдэх хүн ч алга болоод дуусч байх шигээ.

Улаан утсан чинээ голоо тасран тасартлаа эх хэл, ижилгүй бичиг юуныхаа төлөө гав ганцаараа шахам тэмцэлдсэн номч мэргэн Бямбын Ринчен абуйгаа эзгүй, баруун гарынх нь шавь Боржигон Чой.Лувсанжав нь, Жамцын Бадраа нь эзгүй, Монгол бичиг соёлынхоо гайхамшигийг лав гэгч нь ухаарсан, бахархалтай тэмцэгч, баатар Түмэнбаярын Дашцэдэн багштан, их бичээч, нэрт манжич Цэ.Шархүү, Го.Мижиддорж нарын хэн нь ч алгаа. Тэдний минь сүнс сүлдэр Монгол хэл минь, Монгол бичиг минь юу болоод байна? хэмээн биднийхээ мөрөн дээгүүр өнгийн өнгийн харсаар байнам.

Монгол эхийн үрс бүхний ээлийн наран болсон эх хэлийг минь, Монгол бичгийг минь даяаршилын рах залигаж байхад ядаж тогоо, түмпэн нүдэхийн оронд <<Монгол хэл, бичиг хэзээ ч уусахгүй, хэл бол өөрийгөө цэвэршүүлж байдаг>> хэмээн өнөөх их яргачин Сталины <<хэл хутгалдахын онол>> гэдэг шиг юм яриад явдаг <<лухайж гүйцсэн>> эрдэмтэн ч бас байх аж. Тэд Монгол хэл ч хэрэггүй, Монгол бичиг ч хэрэггүй хэмээн давшилтаа эхлэх цаг тийм ч холгүй бололтой.

Англи хэлтэй, латин бичигтэй болно хэмээн “Латин үсгийн үндэсний хөтөлбөр” гэгчийг хэдэн жилийн өмнө боловсруулан, холбогдох газруудад тараачаад цагийн байдал, салхины алс отон сууна. Энэ бүхэн бол мөнөөхөн л гадаад их гүрний шахаа, даяаршил гэдгийн давалгаа болой.

Буриад зоны минь Монгол хэл, Өвөрлөгсөдийн минь Монгол хэл өнөө ямар болсныг мэдсээр, үзсээр байж <<хэл өөрийгөө цэвэршүүлдэг>> гэж <<онхолдох>> нь яв ч эрүүл Монгол хүний үг биш. Эрүүгээ авч нуруугаа мааж... гэхээр л явдал болой.

Эцэст нь дүгнэж хэлэхэд:

Нэгд. Бүх их дээд сургуулиудын анги болгонд Монгол хэл, Монгол хэлний найруулгазүй хичээл заадаг болсон цагт, *хоёрт.* Улсын их хурлын гишүүнд нэр дэвшигч Монгол бичгээрээ уншдаг бичдэг байхын цагт, *гуравт.* Толь бичгүүдийнхээ гажуудлуудыг засаж залруулсан цагт Монгол хэл минь даяаршилд залигуулах аймшгаас зайлж, адлагдаад байсан Монгол бичгээ гартаа авч чадна.

Тайлбар(1): нар, сар хиртэхээр рах залгиж байна гэж түмпэн сав, тогоо шанага цохидог домогтой.

Жич: 1966 оноос хойш гадаад дотоодод хэвлэгдсэн Монгол нь өмнөөх (Монгол-Хятад гэх мэт) бараг бүх толь бичгүүдэд орсон К, П- үсгээр толгойлсон ихэнхи гадаад үгийг Монгол үгсээр оноон орчуулан үйлдсэнээ хавсаргалаа.

К

1. Кабель- утас, шугам
2. Кабина- бүхээг
3. Кабинет- танхим, өрөө, тасалгаа
4. Кадастр- бүртгэн нягтла-, нягтлан дансла-
5. Кадр- хальсны нэг болон хэсэг зураг
6. Казарм- *цэр.* Хуаран
7. Казино- мөрийтэй тоглоом, мөрийцэх газар
8. Кайф- таалал, таашаал
9. Кактус- аршийн алга, аршийн бөмбөлөг
10. Календарь- цагалбар, цаг тооны бичиг
11. Калибр- *цэр.* бага голчит буу, бага голчит
12. Калькулятор- тооны машин
13. Калори- илчийн нэгж
14. Камер- 1. Өрөө, тасалгаа 2. Бохогон олгой 3. Гэрэл зураглуур
15. Камертон- хөглүүр, хөглүүр сэрээ
16. Кампани- хөдөлгөөн, явуулга
17. Кампус- сургуулийн хотхон, сургуулийн хүрээлэн
18. Канат- төмөр аргамж
19. Кандидат-1. нэр дэвшигч, 2. дэд эрдэмтэн

20. Канистер- төмөр хавчиг
21. Канон-олшруулуур, хувилуур
22. Кант- эмжээр, хөвөө
23. Канцлер- дээд түшмэл, ерөнхий сайд
24. Канитал- хөрөнгө
25. Канитализм- хөрөнгөт ёс
26. Каниталист- хөрөнгөт ёсыг баримтлагч
27. Капитан- ахмад
28. Капот- машины хамар
29. Карабин буу- огтор шар
30. Капсуль- бүрхүүл, бүрээс
31. Карамель- голио чихэр, хатуу чихэр
32. Карантин- хөл хорио, хөл цээр
33. Карат- хатуулаг, хатуулац
34. Каратэ- улаан гараараа тулалдах
35. Карго- улс хоорондын ачаа
36. Кардан- *тех.* Дамжуулуур гол
37. Каркас- яс мод
38. Карман- халаас
39. Карниз- хэрдэг, мөгүү
40. Картон- морин цаас, зузаан цаас
41. Карьер- 1. ил уурхай 2. албан тушаал
42. Каск- дуулга, дуулга малгай
43. Касс- 1. тасалбар түгээгүүр 2. мөнгөн гүйлгээний цонх
44. Кассет- хуурцаг
45. Кастрюль- төмөр сав, төмөр хувин
46. Категори- ай, бүлэг, зэрэг
47. Катетер- *Ана.* Бургуй
48. Каучик- бохого
49. Кафе- зогойнцор
50. Кафедр- 1. индэр 2. тэнхим
51. Каш- будаа
52. Квадрат- 1. дөрвөлжин 2. тоог өөрөөр нь үржүүлсэн үржвэр
53. Кварц- өөхөн чулуу
54. Квас- исэг
55. Квитанци- тасалбар
56. Квот- хувь, хэмжээ
57. Кеды- тамирын шаахай
58. Кекс- үзэмт талх
59. Керамзит- царууц тоосго
60. Керамик- вааран эдлэл
61. Керосин- гаршийн тос
62. Кесарев- хийсвэр хийлгэ-
63. Кетчуп- хоол амтлуур
64. Кибернетик- залуурзүйн ухаан
65. Кимчи- чинжүүт ногоо
66. Кинетик- хөдөлгүүрийн хүчзүй
67. Кисель- жимсэт шахмал
68. Кислород- хүчил төрөгч
69. Китель- босоо захат цамц

70. Клапан- хавхлага
71. Кларнет- бялар
72. Классик- сонгодог
73. Клизм- бургуй
74. Клип- утгажуулсан зураглал
75. Клиринг- бэлэн мөнгөний бус тооцоо (улс хооронд)
76. Клуб- улаан булан
77. Кноп- товхот хадаас, малгайт хадаас
78. Код- түлхүүр, томъёолуур
79. Кокс- шатанги нүүрс, хүлэржсэн нүүрс
80. Коктейль- тахианы сүүл дарс, өндөрлөгөөний дарс
81. Колбаса- хиам
82. Коллег- 1. төлөөнөө хүн 2. зөвлөл 3. ажил, мэргэжил нэгтэн
83. Коллеж-дунд сургууль (франц, швецар улсуудад)
84. Коллектор- ном бүрдүүлэлт
85. Коллектив- хамт олон
86. Коллекци- цуглуулга
87. Колодк- гутлын хэвлүүр
88. Колон- эзэмдэн ноёрхох
89. Колонк-түгээх цэг (шингэн түлш)
90. Кольцо- цагираг, дугуй
91. Комбинезон- ажлын хувцас
92. Комендант- 1.цэр. журамлагч 2. аж ахуй. нярав
93. Комисс- 1. хороо, зөвлөл 2. дуудлага худалдаа
94. Коммун- хамтрал
95. Коммунизм- эв хамтын ёс
96. Коммунист- эв хамт намын гишүүн
97. Компани- 1. нэгтгэл 2.хамжаа,хамтрагч
98. Компас- луужин
99. Комплекс- цогцолбор, бүрдэл
100. Комплект- иж бүрэн, иж
101. Композитор- хөгжмийн зохиолч
102. Композици- зохиомж
103. Компот- жимст ундааны нөөш
104. Компресс- бигнүүр, жин (халуун, хүйтэн)
105. Компьютер- цахим тархи
106. Конвейер- туузан дамжуулга
107. Конвенци- гэрээ
108. Конверт- дугуй
109. Конгресс- их хурал
110. Конденсатор- агшаагуур, цахиилгаан хуримтлууур
111. Кондуктор- улаач, тасалбар олгогч
112. Конкурс- сургуульд орох шалгалт, өрсөлдөөнт шалгалт
113. Консерв- нөөш
114. Консерватизм- хуучинсаг үзэл
115. Консерциум- хамтын холбоо
116. Конспект- хураангуй, товчлол
117. Констракшен- барилга байгууламж эрхлэх
118. Конструкци- бүтээц, хам бүтэц
119. Консул- төлөөлөгч, төлөөлөгчийн газар

120. Консультаци- зөвлөгөө, заавар
121. Контакт- авцалдаа, хүрэлцээ, холбоо
122. Контейнер- чингэлэг
123. Контекст- 1.хам бичвэр 2.цаад утга, давхар санаа
124. Контор- албан өрөө
125. Контробанд- хулгайгаар хил давуулах бараа
126. Контрабас- аригил хийл
127. Контракт- гэрээ, хамтын гэрээ
128. Контраст- эрс ялгаа
129. Контрайк- эм эрэг
130. Контроль- шалгалт, хяналт
131. Конус- шовгор, шовоохой
132. Конференци- хурал, бага хурал
133. Конфет- цаастай чихэр
134. Концентраци- өтгөрүүлэх, бөөмрүүлэх
135. Концепци- үзэл баримтлал
136. Концерн- эзэмдэл нэгтгэл, их нэгтгэл
137. Концерт- урлагийн тоглолт
138. Концесси- эрдэс баялаг ашиглах гэрээ
139. Коньяк- шарз, морь-сарлаг
140. Координат- солбицол
141. Копи- хуулбар, хуулга
142. Коридор- гудам, хонгил
143. Костюм- барууны хувцас
144. Котлет- татшин хайрмаг
145. Кофе- боргол цай
146. Кофейн- боргол цайн эм
147. Кофт- бүсгүйн гадуур цамц
148. Коэффициент- илтгэлцүүр, үржүүлэгч тоо
149. Кран- 1. өргүүр цамхаг 2. гоожуурын толгой
150. Крахмал- цардуул
151. Кредит- 1. зээл 2. олгох мөнгө 3. итгэл, нэр хүнд 4. багц цаг
152. Крем- 1. цөцгийн түрхлэг 2. нүүрний тос
153. Кресл- түшлэгт сандал
154. Крест- загалмай
155. Кризис- хямрал
156. Кристал- талст
157. Критери- шалгуур, хэмжүүр
158. Кросс- саадтай уралдаан
159. Ксерокс- хувилуур машин
160. Куб- шоо дөрвөлжин
161. Кузов- машины тэвш
162. Кукол- наадгай, хүүхэлдэй
163. Купе- өрөө, тасалгаа
164. Курс- анги, дамжаа
165. Куртка- хүрэм

II

1. Павильон- үзмэрийн танхим, үзмэрийн өргөө
2. Пайз- гэрэгэ

3. Пайлуур- гэрэлт хөшөө
4. Палас- ордон, өргөө
5. Палат- эмнэлэгийн өрөө
6. Палатк-майхан, цомцог
7. Палеонтолого- эртний шим судлал
8. Пальто- дулаан дээл
9. Памперс- живх
10. Панорам- эргэн тойрны үзэмж
11. Пантокрин- цусан эврэн эм
12. Пантомим- үггүй жүжиглэн, цам
13. Пар- уурын халаагуур
14. Парад- ёслолын жагсаал
15. Парадокс- гаж зүйл, гажууд явдал
16. Паразит- шимэгч
17. Параллель- зэрэгцээ, зэргэд
18. Парашют- шүхэр
19. Парик- хиймэл үс
20. Парк- цэнгэлдэх, цэцэрлэгт хүрээлэн
21. Паркет- зүүмэл шал, царсан зүүмэл
22. Парламент- их хурал
23. Паровоз- уурын тэрэг
24. Пароль- нууц хэл, нууцгай дохио
25. Парт- сандалт ширээ
26. Партер- голын суудал
27. Партизан- журамт цэрэг, анхдагч
28. Партнёр- хослогч, хамтрагч
29. Паспорт- иргэний үнэмлэх
30. Пассив- 1. идэвхигүй, цалгар 2. өртэй
31. Пастил- хөөсөнцөр чихэр
32. Патент- онц эрхийн гэрчилгээ
33. Пентатоник- таван эгшиг, тавцал
34. Пиво- шар исэг
35. Пионер- хошуучлагч
36. Пирамид- сац суварга
37. Плитк- цахилгаан тулга
38. Поп рок- доншуур дуу
39. Практик- дадал, туршлага
40. Примус- цоригуур зуух
41. Принтер- цахим хэвлүүр, цахим хэвлэл
42. Приставк- хуурцгийн дуу, дүрс дамжуулуур
43. Прогноз- төлөг, таамнал, урьдчилсан төлөв
44. Программ- хөтөлбөр
45. Програмист- хөтөлбөрч, хөтөлбөр зохиогч
46. Прокурор- хууль сахиулагч
47. Пролетари- үгээгүй ядуу
48. Протокол- тэмдэглээ
49. Профессор- багштан, их багштан
50. Процент- зууны хувь
51. Процесс- явц, үйл явц, ажиллагаа
52. Процессор- мэдээлэл бодуур